



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

ИЭГ ХОТ СТАНДАРТ

**2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
АЖЛЫН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2022 он**

ГАРЧИГ

НЭГ.ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД БОЛОН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХООРОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ 2022 ОНД ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ.....	3
1.2. НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭ.....	3
Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 2015 стандартын дотоод аудитор бэлтгэх сургалтад хамруулсан.....	3
ХОЁР. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	4
2.1 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ	4
2.2. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ	4
2.2.1 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	4-8
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ	9
3.1 БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ	9
Хотын стандартыг боловсруулах, батлуулах чиглэлээр:	9-11
Хоёрдугаар ээлжинд батлуулах хотын стандартын бэлтгэл ажлын хүрээнд. <u>12-13</u>	
Стандарт норм, дүрмийн судалгааны чиглэлээр:	14-16
3.1.5. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	16-18
3.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	18
3.3 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ТАЙЛАН МЭДЭЭ	19
3.4 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА . <u>20-21</u>	
ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ.....	22
4.2. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	23
4.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ХАНГАХ ХҮРЭЭНД:.....	24
4.3. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	24
ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ	24
5.1. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	24
5.2.1. УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ	24
5.2.2. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ	25
5.3.1. ӨМЧ ХАМГААЛАХ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	25

5.3.2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГТЭЙ ХОЛБОТОЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИД САНАЛ ӨГСӨН БАЙДАЛ	<u>26-27</u>
5.3.4. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖИЛ	<u>28-29</u>
ДҮГНЭЛТ	<u>29-30</u>

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

НЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД БОЛОН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХООРОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ 2022 ОНД ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

1. ОРОН СУУЦНЫ АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭНИЙ АШИГЛАЛТАД ОРСОН НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ БОЛОН АМИНЫ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН 2022 ОНЫ ХАГАС, БҮТЭН ЖИЛИЙН МЭДЭЭ /МАЯГТ А-ОС-1/ БОЛОН АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ БУУЛГАСАН НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ БОЛОН АМИНЫ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН МЭДЭЭ /А-ОС-2/-Г ЗААСАН ХУГАЦААНД ХОЛБОГДОХ ГАЗАРТ ТАЙЛАГНАХ;

Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны барилгын холбогдох 41 мэдээллийн талбар бүхий дэлгэрэнгүй мэдээллийг маягтын дагуу нэгтгэн боловсруулж 2021 оны жилийн эцэс, 2022 оны I улирал, эхний хагас жилийн мэдээллийг Нийслэлийн Статистикийн газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт тус тус хүргүүлсэн.

1.2. НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд тус газрын үйл ажиллагаатай холбоотой хийж хэрэгжүүлэх 4 зорилтын 6 арга хэмжээг газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, баталгаажуулан ажиллав. Энэ ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

Арга хэмжээ: 5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2016, MNS ISO 18091 стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх.

Чанарын менежментийн тогтолцооны 4 дотоод аудитор, 3 сургагч багш бэлтгэхээр төлөвлөн, сургалтад хамруулах ажилтнуудын судалгаа, сургалтын төсвийн саналыг боловсруулж Газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дотоод аудиторын сургалтад Хотын хөгжлийн стандартын хэлтсийн Ахлах мэргэжилтэн М.Дунгармааг G2G сургалтын төвөөс зохион байгуулдаг Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 2015 стандартын дотоод аудитор бэлтгэх сургалтад хамруулсан.



Зураг-1. Дотоод аудиторын сургалт

Мөн менежментийн тогтолцооны сургалт, зөвлөгөө, аудитын үйлчилгээний Эс Эф Си Эс ХХК-тай хамтран стандартын сургалтыг 3 дугаар улиралд явуулахаар төлөвлөж байна.

ХОЁР. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2022 оны хагас жилийн байдлаар тус газрын хэмжээнд Монгол Улсын Их хурлын тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын дараах тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж ажиллав.

2.1.1. Монгол Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор “Төрийн захирагааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилт:

Монгол Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол, Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчид олгох албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг өнгөрсөн оны саналуудтай харьцуулан боловсруулж Газрын удирдлагуудаар хянуулан баталж албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хүний нөөц, удирдлагийн тасагт хүргүүлсэн.

2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Нийслэлийн Засаг даргын тамгын газраас “Төрийн захирагааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” Нийслэлийн Засаг даргын А/641 дүгээр захирамжийг хүлээн авсан. Уг захирамжаар 11 албан хаагчийн зэрэг дэв ахиулан олгогдсон. Захирамжийг газрын удирдлагад танилцуулан төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системд бүртгэн оруулж тухайн сараас эхлэн ахиулан олгогдсон зэргийн нэмэгдлийг албан хаагчдад олгож өхөлсэн ба хувийн хэрэгт хуулбарыг оруулан тус тус баяжуулан ажилласан байна.

2.1.2. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 18 зорилт 60 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан 2022 оны хагас жилийн байдлаар биелэлтийг нэгтгэн гаргаж НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн ажилласан.

2.2. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2.2.1 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус газар нь дүрмээр хүлээсэн чиг үүрэг, нийслэлийн удирдлага, нийслэлийн онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд 2021 оны эхний хагас жилд дараах 10 захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Үүнд:

2.2.1.1 Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/1033 дугаар захирамжийн хэрэгжилт захирамжийн хэрэгжилт:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 130 дугаар тогтоолоор байгуулагдсан нийслэлийн Амьдрах орчны стандартыг шинэчилж сайжруулах санал боловсруулах ажлын хэсэгт хэрэгжилт нь хангалтгүй болон шинээр боловсруулах шаардлагатай стандартын санал боловсруулж, нийт хэлтсүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн ажлын хэсэгт хүргүүлсэн.

Мөн захирамжаар “Хотын стандартыг боловсруулах, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хуралдаанаар 22 бүлэг сэдвийн хүрээнд боловсруулсан 97 төрлийн хотын стандартын баримт бичгүүдээс эхний ээлжийн 9 бүлгийн 38 баримт бичигт холбогдох мэргэжлийн байгууллага, иргэд, аж ахуй нэгж, олон нийтээс санал авч, тусгахаар шийдвэрлсэн бөгөөд саналыг авч холбогдох баримт бичгүүдийг засварлан сайжруулан, НИТХ-аар батлуулах бэлтгэл ажлыг хангуулан 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн чуулганаар хэлэлцүүлэн 1-р ээлжний 9 бүлгийн **38** хотын стандартыг батлуулсан.



Зураг-2. Ажлын хэсгийн хурлын явц

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/491 дүгээр захирамжийн хэрэгжилт захирамжийн хэрэгжилт:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021 оны А/491 дүгээр захирамж “Нийслэл хотын хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг технологийн шийдлийн тусlamжтайгаар сайжруулах, зам, тээврийн ухаалаг нэгдсэн системийг нэвтрүүлэхэд шаардлагатай судалгаа тооцоог гаргах, техникийн даалгавруудыг нэгтгэх ажлыг хэрэгжүүлэх” үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжилтэн Г.Бүтэнбаяр, Ц.Номин, нар Нийслэлийн цахим хөгжил, мэдээлэл технологийн газар, Нийслэлийн Замын хөгжлийн газартай хамтарсан хуралд 2 удаа оролцож “RFID” ухаалаг системийг байршуулах 161 цэгийг тодорхойлох, судалгааны ажлыг гүйцэтгэн ажилласан.



Зураг-3. Ажлын хэсгийн хурлын явц

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/585 дугаар захирамжийн хэрэгжилт:

Захирамжийн хүрээнд Баянзүрх дүүргийн газар зохион байгуулалтын 1-р алба, Баянзүрх дүүргийн цагдаагийн 2-р хэсгийн алба хаагчидтай хамтран дараах ажлыг хийж гүйцэтгэв.

Үүнд:

- 2022.05.19-ний өдөр Газар ашиглалтыг сайжруулах, авто замын түгжрэлийг бууруулах, явган хүний зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбайг нэмэгдүүлэх зорилгоор хууль, журам зөрчсөн, стандарт шаардлагад нийцээгүй хашаа, хайс барьсан зөрчлийг арилгуулахаар Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны 5 байршил, 3-р хорооны 2 байршил, Баянгол дүүргийн 3-р хорооны 1 байршилд газар дээр нь ажиллаж стандарт, норм, дүрэм, арга зүйгээр ханган ажиллав.



Зураг-4. Зөрчилтэй хашаа хайсыг буулгаж байгаа нь

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Эрх шилжүүлэх тухай” А/900 дүгээр захирамжийн хүрээнд:

- 2022.05.20,24-ний өдөр Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Хүннүгийн гудамжны 18 байршилд явган хүний замыг өргөтгөхөөр Нийслэлийн Замын хөгжлийн газар, Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран газар дээр нь үзлэг хийж, хашаа хайсыг буулгуулав.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Сайжруулсан шахмал түлшний нөөцлөлт, түгээлт, борлуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих тухай” А/779 дүгээр захирамжийн хүрээнд:

2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 01/04 дугаартай Хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 15,17 дугаар хорооны агаарын чанарыг сайжруулах бүсэд гэр хорооллын айл өрх зөвшөөрөлгүй түүхий нүүрс түлж байгаа эсэхэд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудын хамтарсан үзлэг хийж нийт 238 өрхөд зуухны битүүмжлэл, түлшний хэрэглээ,

угаарын хийнээс урьдчилан сэргийлэх, сайжруулсан шахмал түлшний галлагаа болон яндан зуухны аюулгүй байдлыг хангах талаар зөвлөмж өгч ажиллав.

Хүснэгт-1. Сайжруулсан түлшний галлагаанд хяналт тавьсан байдал

Д/д	Зураг	Тайлбар
1		Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Ё.Отгонжаргал, Хотын стандарт, хяналтын газрын мэргэжилтэн Д.Номин, Б.Ундармаа Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны зохион байгуулагч Г.Алтанцэцэг нар 12 цагийн байдлаар мэдээ хургуулэхээр ажиллаж буй байдал
2		Айл өрхүүдийн түлшний нөөцлөлт: Хурдан шатах, тэсрэх, дэлбэрэх зүйлсээс хол агааржуулалт сайтай, чийг авахгүй, усанд норохгүй нөхцөлд 1.5 м-ээс өндөргүй нөхцөлд хадгалсан байдал
3		Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны өрхийн шаардлага хангасан энгийн зуух: Зуух, пийшин, яндангийн битүүмжлэл сайн, эвдрэл, гэмтэлгүй.
4		Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны өрхийн шаардлага хангасан ханан пийшин: Ханан пийшин зуухны холбоос нүх, ан цавгүй байгаа нь "UCS 1511 Зуух, пийшин, яндангийн бүрэн бүтэн байдал, галлагаанд тавигдах шаардлага"-ыг хангасан байна.
5		Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны халуун усны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын нам даралтын зуух
6		Зуухыг тэгш, хөдөлгөөнгүй хэсэгт галд тэсвэртэй үл шатах материал дээр байршуулсан нь "UCS 1511 Зуух, пийшин, яндангийн бүрэн бүтэн байдал, галлагаанд тавигдах шаардлага"-ыг хангасан байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай” А/448 дугаар захирамжийн хэрэгжилт:

2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн газрын даргын " Эд хөрөнгийн үзлэг, тооллого зохион байгуулах тухай" А/27 дугаар тушаалаар эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах комиссыг байгуусан. Газрын эзэмшилд ашиглагдаж буй эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг холбогдох хууль, журам, зааврын дагуу 2022 оны 05 дугаар сарын 02-20-ны хооронд зохион байгуулан эд хөрөнгийн улсын үзлэг тооллого зохион байгуулсан тухай илтгэх хуудас холбогдох материалыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2022 оны 01/268 дугаарын албан бичгээр хүргүүлсэн.

Хотын стандарт, хяналтын газрын албан хаагчид НЗД-ын болон бусад албан тушаалтны шийдвэрээр дараах ажлын хэсэгт орж ажиллаж байна.

Үүнд:

Хүснэгт 2. Албан хаагчдын ажиллаж буй ажлын хэсгийн жагсаалт

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Утга	Оролцогч, оролцооны хэлбэр
1	"Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/900 дугаар захирамж	Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх Улаанбаатар хотын авто замын салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тухай	Д.Өлзийсайхан -АХ-ийн гишүүн
2	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамж	Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах арга хэмжээ	Н.Билэгсайхан -АХ-ийн гишүүн
3	Нийслэлийн Засаг даргын захирамж 2021 оны А/1033 дугаар захирамж	Хотын стандарт боловсруулж батлуулах ажлын хэсэг	С.Төмөрдулам -АХ-ийн гишүүн Э.Даваахатан -АХ-ийн нарийн бичгийн дарга
4	"Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/60 дугаар тушаал	Төрийн үйлчилгээний үр дүнг бодитой үнэлэх, дахин загварчлах ажлын хэсэг	Б.Батчимэг - АХ-ийн гишүүн
5	"Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/476 дугаар захирамж	Нийтийн эзэмшлийн газарт болон эзэмшиж, ашиглаж байгаа газраа дур мэдэн нэмэгдүүлж, зохих зөвшөөрөлгүйгээр хашаа, хайс барьсан зөрчлийг арилгаж, газар чөлөөлөх тухай	Д.Өлзийсайхан - АХ-ийн гишүүн
6	НЗД-ын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны А/575 дугаар захирамж	Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, авто замын түгжрэлийг бууруулах талаар санал, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийн талаар мэдээлэл хүргэх.	М.Цогтбилэг - АХ-ийн гишүүн
7	Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/585 дугаар захирамж	Хууль, журам зөрчсөн, стандартын бус хашаа, хайс барьсан газруудын зөрчлийг арилгаж, газар чөлөөлөх тухай	Д.Өлзийсайхан -АХ-ийн гишүүн

8	Нийслэлийн Засаг даргын захирамж 2022 оны А/851 дугаар захирамж	Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах	Нийт хэлтсийн албан хаагчид
9	Нийслэлийн Засаг даргын захирамж 2022 оны А/812 дугаар захирамж	Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг	С.Төмөрдулам -АХ-ийн гишүүн
10	Нийслэлийн Засаг даргын захирамж 2022 оны А/861 дугаар захирамж	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлэхүүнийг шинэчлэн батлах тухай	С.Төмөрдулам -АХ-ийн гишүүн О.Оджаргал -АХ-ийн нарийн бичгийн дарга

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ


3.1 БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Арга хэмжээ: 6.1.5: Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2022 онд боловсруулах 9 бүлгийн 15 хотын стандарт, 9 бүлэг сэдвийн судалгаа хийж гүйцэтгэх “Хотын стандарт боловсруулах тухай” болон “Стандарт норм дүрмийн судалгаа хийх тухай” Газрын даргын тушаалын төслийг боловсруулан, хэлтсийн дарга нараас санал аван нэгтгэж 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/21, А/22 тушаалыг Газрын даргаар батлуулав.

Хотын стандартыг боловсруулах, батлуулах чиглэлээр:

Хотын стандартыг НИТХ-д өргөн барьж батлуулахтай холбоотойгоор, 10 бүлгийн 41 хотын стандартын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 62.1-д заасны дагуу 2022 оны 01 дүгээр сарын 11-ээс эхлэн 02 дугаар сарын 12-ны хооронд Ulaanbaatar.mn болон Хотын стандарт, хяналтын газрын цахим хуудсаар дамжуулан дараах байдлаар саналыг албан бичгээр болон цахимаар тус тус 30 хоног санал авах ажлыг зохион байгуулсан.



Зураг-05. Баримт бичигт санал авахаар байршуулсан загвар зураг

Цахимаар ирүүлсэн санал асуулгад нийт 37411 иргэн, 110 байгууллага, ААН оролцож санал өгсөн. Нийт санал өгсөн иргэд аж аж ахуйн нэгж байгууллагын **77,1%** нь төрийн байгууллага, **15,1%** нь иргэд, үлдсэн **7,8%** нь хувийн хэвшлийн байгууллагын ажилчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид эзэлж байна. **Үүнээс:**

- Бүрэн дэмжсэн /саналгүй/- 10769
- Санал өгч дэмжсэн- 16680
- Тухайлсан заалтад өгсөн- 548
- Тухайн стандартад хамааралгүй 9414 саналыг тус тус ирүүлсэн.

Тухайлсан заалтад ирүүлсэн нийт 548 саналыг холбогдох хотын стандартын төсөлд тусгасан.

Хүснэгт-3 Нийслэлийн харьяа байгууллагуудаас ирсэн санал

Д/д	Санал авахаар албан бичиг хүргүүлсэн байгууллагууд	Тоо хэмжээ	Санал ирүүлсэн байгууллагууд	Ирүүлсэн саналын тоо
1	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг	31	27	109
2	Дүүрэг	9	5	482
3	Хороо	171	51	1470
4	Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль	141	74	8765
5	Хүүхдийн цэцэрлэг	269	158	8811
6	Нийслэлийн өмчит төсөвт байгууллага	19	10	1827
7	Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот байгууллага	35	16	1310
8	Эрүүл мэндийн байгууллага	9	5	704
9	Төслийн нэгжүүд	5	4	58
10	Бусад	6	4	108
11	Төрийн бус байгууллага	1	-	-
НИЙТ		696	354	23644


Албан бичгээр санал ирүүлсэн Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагуудын **93,5 %** нь санал ирүүлсэнээс ба **61,2%** нь тухайлсан саналтай, **38,5%** нь ерөнхий саналаар дэмжсэн байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн нийт 149 тухайлсан саналыг судлан шинжилж 104 саналыг холбогдох хотын стандартын төсөлд тусгасан. Нийслэлийн байгууллагуудаас ирүүлсэн 45 саналыг дараах шалтгааныг үндэслэн тусгаагүй болно.

Үүнд:

- Стандарт, норм, дүрэм, журмаар зохицуулагддаг асуудлуудыг стандартад тусгах саналууд ирүүлсэн;
- Хотын стандартын баримт бичгийн бүрэн уншиж судлаагүйн улмаас стандартад тусгагдсан шаардлага, заалтыг давхардуулсан;
- Хууль, дүрэм, журам болон бусад баримт бичгээр зохицуулагдах харилцааны асуудлуудын санал;
- Үндэсний стандарт болон барилгын норм дүрэм болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөх шаардлагуудыг ирүүлсэн зэрэг болно.


Санал авсан 10 бүлэг хотын стандартаас хамгийн их саналыг “Нийгмийн дэд бүтэц” бүлэгт 52 санал, “Ногоон байгууламж” бүлэгт 29 санал, “Зорчигч тээврийн үйлчилгээ” бүлэгт 29 саналыг тус тус ирүүлсэн байна.

Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллага болон Иргэд олон нийтээс ирүүлсэн саналыг үндэслэн нийт 38 баримт бичигт засвар сайжруулалт хийв. Үүнд:



Зураг-6. Засвар сайжруулалт хийсэн хотын стандартын баримт бичиг

Хотын стандартын баримт бичгийн төсөлд санал авахтай холбоотой Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагатай цахимаар болон биечлэн уулзалт зохион байгуулсан.



Зураг-7. Хотын стандартын талаар уулзалт

стандартыг боловсруулах, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулсан. Ажлын хэсэг 1-р ээлжээр батлуулах 38-н хотын стандартын баримт бичгийг засварлан сайжруулан 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн чуулганаар хэлэлцүүлэн 1-р ээлжний 9 бүлгийн **38** хотын стандартыг батлуулсан.




Зураг-8. Хотын стандартыг НИТХ-аар батлуулах ажил

Хоёрдугаар ээлжинд батлуулах хотын стандартын бэлтгэл ажлын хүрээнд.

Хотын стандартыг 2-р ээлжинд батлуухтай холбоотойгоор 11 бүлгийн 33 баримт бичгийн төсөлд 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дараах байдлаар саналыг албан бичгээр болон цахим санал хэлбэрээр авсан. Үүнд:

1. Нийслэлийн Засаг Даргын Хэрэгжүүлэгч агентлаг-33 байгууллага;
2. Нийслэлийн харьяа **619** байгууллага;
3. Цахим хэлбэрээр буюу олон нийтийн сүлжээ, веб сайтад google форум байршуулан саналыг тус тус авсан.



Хүснэгт-4 Нийслэлийн харьяа байгууллагуудаас ирсэн санал

Д/д	Санал авахаар албан бичиг хүргүүлсэн байгууллагууд	Тоо хэмжээ	Санал ирүүлсэн байгууллагууд	Ирүүлсэн саналын тоо
1	Нийслэлийн Засаг Даргын Хэрэгжүүлэгч агентлаг	33	21	91
2	Нийслэлийн харьяа байгууллага	632	260	
3	Цахим хэлбэр буюу санал асуулгаар	-		
	НИЙТ	665	281	12600

Нийслэлийн Засаг Даргын Хэрэгжүүлэгч 33 агентлагаас **65%** нь санал ирүүлсэнээс **40%** нь тухайлсан саналтай, **25%** нь ерөнхий саналаар дэмжсэн байна. Нийслэлийн харьяа байгууллагаас саналыг Google form-д саналыг тусгувлан авсан бөгөөд нийт байгууллагын **40%** нь ерөнхий саналаар дэмжин, санал ирүүлсэн байна.

Google forum буюу цахим санал асуулгын хэлбэрээр 11 бүлгийн 33 Хотын стандартын төсөлд давхардсан тоогоор **12600** санал ирүүлсэнээс, **23%** нь Барилгын материалын чанар, **17%** нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүртээмжтжий дэд бүтэц, **13%** нь Үер борооны байгууламж бүлэг сэдэв дээр саналууд тус тус ирүүлсэн байна.

График-1 Хотын стандартын баримт бичгийн төсөлд ирүүлсэн санал



**ХОТЫН СТАНДАРТЫН УДИРДАМЖ АРГА ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙГ
САЙЖРУУЛАЛТ ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

Хотын стандарт, удирдамж, арга зүйн баримт бичгүүдийн зураг төслийг стандарт, норм дүрмийг судалсны үндсэн дээр сайжруулалтын ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Хүснэгт-5 Сайжруулалт хийсэн баримт бичиг


№	Бүлгийн нэр	№	Баримт бичгийн нэр
1	Гудамж, зам, барилга байгууламжийн хаягжилт	1	UCS2101A Төрийн байгууллагын нэрийн тэмдэг
2	Амины сууц	2	UCS 0401B Амины сууц, эдэлбэр газрын төлөвлөлт ашиглалтад тавигдах ерөнхий шаардлага
3	Бие даасан инженерийн дэд бүтэц	3	UCS 0703B Худаг, ус агуулах сав, усан хангамж, бие даасан ундны ус цэвэршүүлэх байгууламж
		4	UCS 0704B Бохир усны цооног, бие даасан цэвэрлэх байгууламж
		5	UCS 0702B Бие даасан дулаан хангамжийн тоног төхөөрөмж сонгон хэрэглэх, төлөвлөх ерөнхий шаардлага
4	Дуу чимээний бохирдол	6	UCS 2001A Дуу чимээний бохирдлын менежмент
		7	UCS 2002A Дуу чимээний бохирдлын төрөл ангилал, хулцэх хэмжээ, хориглох зүйлс
		8	UCS 2003A Дуу чимээний бохирдлыг бууруулах технологи, арга зүйн удирдамж
5	Барилгын материалын чанар стандартын ерөнхий шаардлага, баталгаажуулалт	9	UCS 1501C Барилгын бүтээцийн материал /өргийн материал, бетон, арматур/ түүнд тавигдах ерөнхий шаардлага
		10	UCS 1503C Ур ус тусгаарлагч материал
		11	UCS 1507C Халаалт агаар сэлгэлтийн материалд тавигдах ерөнхий шаардлага
		12	UCS 1508C Сантехникийн материалд тавигдах шаардлага
		13	UCS 1510C Цахилгаан шат
		14	UCS 1502C Дүүргэгч материал
		15	UCS 1504C Хаалга цонх
		16	UCS 1505C Дулаан, дуу чимээ тусгаарлах материалд тавигдах ерөнхий шаардлага
		17	UCS 1506C Заслын материалд тавигдах ерөнхий шаардлага
		18	UCS 1511C Зуух, пийшин, яндангийн бүрэн бүтэн байдал, галлагаанд тавигдах шаардлага
6		19	Бие даасан нарны цахилгаан үүсгүүрийн төлөвлөлт, ашиглалт, суурилуулалтад тавигдах шаардлага
		20	Теле хяналтын системийг төлөвлөх, байгуулах, ашиглах удирдамж

Стандарт норм, дүрмийн судалгааны чиглэлээр:

2022 оны 04 дүгээр сарын 07-20-ны өдрийн хооронд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас салбарын үйл ажиллагаанд дагаж, мөрддөг стандарт, техникийн зохицуулалт, норм, дүрмийн асуулга судалгааг нэгтгэн хийж гүйцэтгэлээ. Судалгааг нийслэлийн нутгийн захиргааны нийт 97 байгууллага хамрагдсан. Судалгаанд хамрагдсан нийт **97** Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас **59** байгууллага албан бичгийн хариу ирүүлсэн ба **25** байгууллага тухайлсан санал ирүүлсэн, **38** байгууллага саналгүй албан бичиг ирүүлсэн.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдалд өмнөх судалгаанд тусгагдаагүй шинээр боловсруулах шаардлагатай **10** стандарт, шинэчлэн боловсруулах шаардлагатай **27** стандарт, шинээр боловсруулах шаардлагатай **10** БНБД, шинэчлэн боловсруулах шаардлагатай **51** барилгын норм ба дурэм байна гэж санал ирүүлсэн байна.

График-2. Шинээр болон шинэчлэн боловсруулах Стандарт, БНБД, БД-ийн саналын тоо



Судалгаанд боловсруулалт хийж нэгтгэн шинэчлэх болон шинээр боловсруулах шаардлагатай Барилгын норм ба дүрэм болон Барилгын дүрмийн саналыг Барилга хөгжлийн төв-д 2022 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 01/298 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Стандартын сүурь судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэв.

Үүнд:

- Улаанбаатар хотын гэр хорооллын нүхэн жорлонгийн судалгаа авах тухай 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 01/69-01/75 дугаартай албан бичгийг нийслэлийн 7 дүүрэгт хүргүүлсэн. Ирүүлсэн судалгааг нэгтгэж, Нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд нийт 173463 өрхийн 133194 нүхэн жорлон ашиглаж байгаагаас стандартын шаардлага хангахгүй, хүрээлэн буй орчин болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа 121348 /91%/ нүхэн жорлонгийн тоон судалгааг гаргасан.
 - Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 50 ангиллын нийт 6747 /Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газар <https://estandard.gov.mn/mongoliin-standartiin-jagsaalt-mon/v/290#/> стандарт байгаагаас хөрсний чанар, хөрсний бохирдол, түүнээс хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой 17, усны


- чанар, байгалийн ус, бохир ус, ундны болон үйлдвэрлэлийн ус, хаягдал ус, ус дахин ашиглах асуудалтай холбоотой 23 стандартын жагсаалтыг гаргасан.
- Улаанбаатар хотын хэмжээнд түүхий нүүрс түлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгаа ирүүлэх тухай 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01/68 дугаартай албан бичгийг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт хүргүүлэв.
 - Барилгын гадна орчны аюулгүй байдал болон сууц өмчлөгчдийн холбоодын гадна орчны судалгааг ирүүлэх тухай 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02/25 дугаартай албан бичгийг нийслэлийн 9 дүүрэгт хүргүүлсэн.
 - Орчны аюулгүй байдлын чиглэлээр хийгдсэн 12 төрлийн судалгааг шинэчлэх зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 02 дугаар сарын 09-ний өдрүүдэд ажиллан судалгааны дүн мэдээг нэгтгэв. Нийслэлийн 23 тойргоор ялгаж бэлтгэв.

ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭР ХИЙГДСЭН СУДАЛГАА



График-3. Судалгааны нэгдсэн тоон мэдээ


Хөрсний бохирдлыг бууруулахтай холбоотой стандарт, шаардлагыг боловсруулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын усан сан бүхий газрын нүхэн жорлонгоор байгууллагын орон зайн мэдээллийн санг баяжуулж, сэдэвчилсэн зураг бэлтгэв.



Зураг-9. Усан сан бүхий газрын нүхэн жорлонгийн зураг


Сургалтын чиглэлээр:

Хотын стандартын 38 баримт бичиг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсантай холбоотойгоор Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, хамтран сэдэвчилсэн сургалтыг нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хотын стандартыг сурталчлан таниулах зорилгоор “Хог хаягдлын менежмен” бүлгийн “Хог хаягдал цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн удирамж” гэсэн нэр бүхий баримт бичгийн сургалтын Хан-Уул, Налайх, Багахангай дүүргүүдэд зохион байгуулан ажиллалаа.



Зураг-10. Хотын стандартын сэдэвчилсэн сургалт

Худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа эрхлэгчид болон Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардахгүй 74 төрлийн үйл ажиллагаанд шаардлагатай хотын стандартын талаар мэдээ, мэдээллийг иргэн, аж ахуй нэгж байгууллага, мэргэжлийн холбоодод танилцуулах хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг нийслэлийн 9 дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна. 2022.06.21-ний байдлаар 8 дүүргийн 740 үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад сургалт зохион байгуулав.



Зураг-11. Сургалтын явц

3.1.5. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны A/239 дүгээр захирамжийн дагуу Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралт, их засвар, шинэчлэлт, тохиижилтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг батлагдсан 20 хуваарийн дагуу зохион байгуулж ажиллав.

Үүнд:


- Барилга байгууламжийн	136
- Гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлэг	174
- Их засвар, шинэчлэлт, тохижилтын ажлын	59



Зураг-12. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж буй явц



Зураг-13. Гадна цахилгаан хангамжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж буй явц




/Зураг-14. Агаарын трансформаторын дэд өртөө /АТП/



Зураг-15. Гадна тохижилтын ажлыг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж буй явц

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт баталгаажуулах, ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээллээр орон зайн мэдээллийн санг баяжуулах барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн мэдээллийг QGIS, Орчны аюулгүй байдлын мэдээллийн санд <https://standard.ub.gov.mn> холбоосор дамжин орж холбогдох шаардлагатай мэдээллийг хянаж иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламж 140, их засвар, тохижилт 62, эрчим хүчний барилга байгууламж 174 ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг баталгаажуулан дугаар олгосон.



Зураг-16 /Орон зайн мэдээлэл/

3.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2022 оны эхний хагас жилийн байдлаар хүний нөөцийн бодлого, хэрэгжилттэй холбоотой 28 “Б” тушаалын төслийг боловсруулан газрын даргаар баталгаажуулсан бол Үндсэн үйл ажиллагаатай холбоотой 36 “А” тушаалыг боловсруулсан. А,Б тушаалын төслийг хэвлэмэл хуудсан буулгаж тэмдэг дарж, дугаар олгон ажилласан нийт 64 газрын даргын шийдвэрийг албажуулан ажиллав.

Нийслэлийн Засаг даргын 2022.01.31-ний өдрийн A/112 дугаар захирамжаар газрын дүрэм батлагдсан. Батлагдан дүрэмд нийцүүлэн байгууллагын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалт, ангилал зэрэглэлийг A/01 дүгээр тушаалаар батлуулж, хэлтсүүдийн чиг уургийг дахин хувиарлан хэлтсүүдийн үйл ажиллагааны дүрмийг газрын даргын A/02 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Газрын албан тушаалын тодорхойлолтыг шинэчилсэн дүрэмд нийцүүлэн хэлтсүүдтэй хамтран боловсруулж Төрийн албаны зөвлөлийн 2022.05.11-ний өдрийн 330 дугаар тогтоолоор Төрийн захиргааны 36 албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан.

Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах 2022 оны төлөвлөгөөнд 12 арга хэмжээг төлөвлөн газрын даргаар 2022.02.11-ний өдөр батлуулсан. Дээрх арга хэмжээний 5 арга хэмжээг зохих шатанд хэрэгжүүлэн ажилласан.

- Албан хаагчдын ажилласан жил, мэргэжил, ур чадварыг үндэслэн нэмэгдэл олгуулах санал боловсруулж газрын даргын 2022.02.22-ны өдрийн A/04 дүгээр тушаалаар 15 албан хаагчдын шатлал ахиулан олгуулсан.
- 12 албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулах санал боловсруулж 2022 оны 2-р сард хүргүүлэн НЗД-ийн 2022.05.12-ны өдрийн A/641 дүгээр захирамжаар 11 албан хаагчид зэргийн нэмэгдэл олгуулсан.

- Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээ, судалгааг тухай бүр холбогдох дээд шатны байгууллагад тайлагнасан.
- Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд НЗДТГ-ийн ХНХТөвийн төлөвлөгөөт сургалтад 38 албан хаагчийг танхимаар болон цахимаар хамруулсан.
- Ажилд томилогдсон албан хаагчдыг харьяа дүүргийн эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулсны үндсэн дээр ажилд томилсон.


3.3 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ТАЙЛАН МЭДЭЭ

3.3.1 2022 оны хагас жилийн байдлаар байгууллагын хэмжээнд хяналтад авагдсан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2018_258 дугаар тогтоолоор 11, 2021 оны 2021_45 дугаар тогтоолоор 1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 119 дүгээр тогтоолоор 1 үүрэг даалгавар өгөгдсөн нийт 13 заалтын хүрээнд дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүн, мэдээнд хяналт шинжилгээ хийж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдүгээр улирлын мэдээг нэгтгэн гаргаж тогтоол шийдвэрийн нэгдүгээр улирал хагас жилийн биелэлтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст албан бичгээр хүргүүлэв.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөнд тус газрын хэрэгжүүлэхээр тусгагдсан 11 зорилт арга хэмжээ, Нийслэлийг 2022 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан 9 зорилт арга хэмжээний хэрэгжилтэд 2022 оны нэгдүгээр улирал, хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ танилцуулгыг удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.

Нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан” lmonitoring.ulaanbaatar.mn-д Нийслэлийн Засаг даргын захирамж-5, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл-3 нийт 8 дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн гаргаж тайлagnan ажиллав.

График-3 lmonitoring.ulaanbaatar.mn-д тайлагнасан байдал.



3.4 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022 оны хагас жилийн байдлаар байгууллагын хэмжээнд нийт ирсэн, явсан бичиг иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг харуулав.



/График-4: Албан бичиг шийдвэрлэлт/

2022 оны хагас жилийн байдлаар 119 иргэн доорх ангиллаар хандсан байна. 110 асуудлын 84-ийг тухайн иргэний талд, 11 иргэний асуудал чиг үүргийн дагуу шийдвэрлэх боломжгүй, бусад байдлаар 7 асуудлыг шийдвэрлэсэн байна.

Ирүүлсэн асуудлыг төрлөөр ангилвал;

1. Хүсэлт 72-н 70-г шийдвэрлэсэн 2 хүсэлт шийдвэрлэгдээгүй судалж байна,
2. Санал 6 ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн,
3. Гомдол 41 ирсний 34-г шийдвэрлэсэн 6 гомдол шийдвэрлэгдээгүй судлах шатанд байна.

Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт иргэний талд болон бусад хэлбэрээр шийдвэрлэгдсэн байдал;

Иргэний талд	84,
Боломжгүй	11,
Бусад	7

Архивын ажлын хүрээнд:

Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн удирдлагын нийтлэг баримт бичиг хадгалах, хөмрөг үүсгэх, хадгаламжийн нэгж бүрдүүлэх, хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын дагуу бүрдүүлсэн баримт бичгийг, нягтлан шалгаж, эмхлэн цэгцлэх, сэлбэн засах сэргээн шинэтгэх ажлууд хийгдсэн. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 онд хөтлөгдөх 54 хэргийн цаасан суурьтай 207 хадгаламжийн нэгжийн, баримт бичгийн бурдэл, стандартыг шалгаж хуваарийн дагуу хүлээн авсан.


Хүлээн авсан баримтуудын хадгалах хугацааг тогтоох, тэдгээрийг байнгын хадгалалтанд сонгох зорилгоор баримт бүрийн үнэ цэнийг нягтлан шалгаж, эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийв.

Архивт хүлээн авсан цаасан суурьтай

- Байнга хадгалах 18166 хуудас 105 боть
 - Түр хадгалах 13351 хуудас 96 боть
 - 70 жил хадгалах 1142 хуудас 7 боть
- Нийт 208 боть хадгаламжийн нэгж,

Тусгай төрлийн буюу цахим 9 хадгаламжийн нэгж тус бүрд техник боловсруулалт хийсэн байдалд баримт бичгийн нягтлан шалгалт хийж зөрчилтэй буюу засвартай баримт бичгүүдийг стандартын дагуу болгон зөрчлийг арилгуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Архивын сан хөмрөгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавин стандартад нийцсэн хадгаламжийн нэгжийг бүрдүүлж, үр дүнг тайлганаа


Газрын даргын 2021 оны А/01-45, Б/01-58 тушаалыг ARCHIVE EDOC системд оруулж, нягтлан шалгалт хийж, НАГ-аар хянуулав. Тушаал нэг бүрийн мастер хувийг, OFFICE DOCUMENT-д байршуулж, DVD хуулж цахим баримтын бүртгэл хөтлөв. Цахим хувийг НАГ-ын Төрийн архивын санд хүлээлгэн өгөв. Актаар баталгаажуулав.



**Зураг-17 НАГ-Д ЦАХИМААР
ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН БАЙДАЛ**

**Зураг-18 ARCHIVE EDOC
СИСТЕМД ОРУУЛСАН**

Газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/13 дугаар тушаалаар БНШК-ын бүрэлдэхүүн шинэчлэн байгуулж, БНШК-ын дурмийг батлуулав.



ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН:

Монгол Улсын засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн A/1059 дүгээр захирамжаар удирдлага /дарга, орлогч дарга/, зохион байгуулалтын 6 нэгж, нийт 60 хүртэлх албан хаагчтай байхаар бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан. Бүтцийн нэгжид дараах өөрчлөлт орсноор газрын чиг үүргийг хэрэгжүүлэхэд илүү оновчтой зохион байгуулалт бий болсон.


Шинэчилсэн бүтцийн харьцуулалт

Өмнөх бүтэц /НЗД-ын 2020 оны A/1011 дүгээр захирамж/	Шинэчилсэн бүтэц /НЗД-ын 2021 оны A/1059 дүгээр захирамж/
<ul style="list-style-type: none"> - Удирдлага /дарга, орлогч дарга/ - Захиргааны хэлтэс - Бодлого төлөвлөлтийн хэлтэс - Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтэс - Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс - Барилга байгууламжийн хяналтын хэлтэс - Мэдээлэл технологийн хэлтэс 	<ul style="list-style-type: none"> - Удирдлага /дарга, орлогч дарга/ - Захиргаа, санхүүгийн хэлтэс - Хотын хөгжлийн стандартын хэлтэс - Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс - Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтэс - Байгаль орчны стандартын хэлтэс - Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтэс

Зураг-21 Хотын стандарт, хяналтын газрын үндсэн чиг үүргийн дахин хуваарилалт

ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



№	Газрын үндсэн чиг үүрэг	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Хотын хөгжлийн стандартын хэлтэс	Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтэс	Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс	Байгаль орчны стандартын хэлтэс	Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтэс
1	4.1.1 ... хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх		Нэгдсэн бодлогын хэрэгжилт				Хариуцсан салбарын хүрээнд
2	4.1.2 ... хотын стандартыг боловсруулах, батгуулах, хэрэгжилтэд хяналт тавих			Хариуцсан салбар, чиглэлээр стандарт боловсруулж баттуулах			Ханах
3	4.1.3 ... удирдамж, арга зүйн тогтолцоог хөгжүүлэх						хэрэгжилтийг хянах, зөвлөн туслах
4	4.1.4 ...лавлагaa, мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх		Нэгдсэн павлагaa, мэдээллийн сан бүрдүүлэх		Хариуцсан салбарын хүрээнд		
5	4.1.5 ... мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх			Хотын стандартыг хэрхэн баттуулах талаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх /бусад байгууллагуудад/			
6	4.1.6 хотын стандартын талаарх сургалт, сурталчилгаа			Хариуцсан салбарын хүрээнд сургалт, сурталчилгаа хийх			
7	4.1.7.. барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс						Үндсэн чиг үүрэг

■ Захиргааны дэмжклэг ■ Үндсэн хариуцах ■ Хамтран ажиллах

4.2. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэд, олон нийтийн хотын стандартын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах, газрын үйл ажиллагааг ил тод байлгах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дараах мэдээ мэдээлэл өгөв. Үүнд:

- 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр “Гадна зар сурталчилгааны байгууламж” сэдвийн хүрээнд Монгол Эйч Ди телевизэд хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цогтбилэг Хотын стандартын баримт бичиг болон иргэд олон нийтээс санал авч буй талаар ярилцлага, мэдээлэл
- 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Гудамж, зам талбайн стандарт хариуцсан мэргэжилтэн Э.Гэрэлт-Од явган хүний замын стандарт түүний хэрэгжилтийн талаар Монголын Үндэсний телевизэд ярилцлага




Зураг-22. Ярилцлага өгч буй явц

- Мөн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цогтбилэг “Явган хүний замын стандарт”-ын талаар Монголын Үндэсний Радио Телевизэд ярилцлага

4.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ХАНГАХ ХҮРЭЭНД:

Байгууллагын цахим хуудсанд хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой /хөдөлмөрийн дотоод дүрэм, ёс зүйн журам, үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал, сул орон тооны мэдээлэл, албан хаагчдын холбоо барих мэдээлэл.../ гэх мэт 15 төрлийн мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас



www.standard.ub.gov.mn -д байршуулсан.

/Зураг-23 Байгууллагын цахим хуудсанд хүний нөөцийн мэдээлэл байршуулсан/

- Газрын нийт албан хаагчдад тухай бүрт батлагдан гарсан тушаал, шийдвэрийг танилцуулах, цаг үеийн мэдээллийг тургэн шуурхай хүргэх, байгууллагын хэмжээнд дагаж, мөрдөх дүрэм журам, журмын шинэчлэлт, шинээр томилогдсон болон сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын мэдээллийг танилцуулах сонсох ажиллагааг тухай бүрт зохион байгуулж ажлын фейсбуук группд зарим холбоотой мэдээллийг оруулан, албан хаагчдыг мэдээллээ цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн.

4.3. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн ажиллаж, шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд буюу сар бүрийн 08-ны өдөр шилэн дансны нэгдсэн системд мэдээллийн байршуулан ажиллаж байна. 2022 оны хагас жилийн байдлаар нийт 6 удаа байршуулж ажиллав.

ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.2.1. УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хурал болон нийт албан хаагчийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

2022 оны хагас жилийн байдлаар Удирдлагын зөвлөл нийт 6 удаа хуралдаж нийт 23 цаг үеийн асуудлыг шийдвэрлэсэн. Тухай бүр хурлын төлөвлөгөө, хурлын

тэмдэглэл, төлөвлөгөөний биелэлтийг тус тус гаргаж хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг тухай бүрт нь газрын даргад тайлагнаж, хурлын протоколыг гишүүдээр баталгаажуулан ажиллав.

5.2.2. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ

5.2.2.1 Нийслэлийн Засаг даргын Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар:

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас 14 удаагийн цахим шуурхай хурлаас нийт өгөгдсөн 56 үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн гаргаж удирдлагад танилцуулан тухай бүр Улаанбаатар.мн цахим системд тайлагнан ажиллав.

График-5 Өгөгдсөн үүрэг даалгавар, биелэлт



5.2.2.2 Байгууллагын цаг үеийн ажлын төлөвлөгөөний биелэлт

Газрын цаг үеийн ажлын төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нийт 6 удаа боловсруулан газрын даргаар батлуулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг холбогдох хэлтсүүдээс тухай бүр авч нэгтгэн, биелэлтийн дундаж хувийг гарган удирдлагад танилцуулан ажиллав. Үүнд:

Хүснэгт-6: Цаг үеийн ажлын төлөвлөгөөний биелэлт

№	Хамрах хугацаа	Үйл ажиллагааны тоо	Биелэлтийн дундаж хувь
1	2022.01.04-2022.02.01	39	63%
2	2022.02.07-2022.02.28	21	85%
3	2022.03.01-2022.03.31	28	84.6%
4	2022.04.01-2022.04.30	39	86.4%
5	2022.05.01-2022.05.31	31	75%
6	2022.06.01-2022.06.31	38	80%
НИЙТ		196 /давхардсан тоогоор/	64 хувь

5.3.1. ӨМЧ ХАМГААЛАХ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн газрын даргын "Эд хөрөнгийн үзлэг, тооллого зохион байгуулах тухай" А/27 дугаар тушаалаар эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах комиссыг байгуусан. Газрын эзэмшилд ашиглагдаж буй

Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг холбогдох хууль, журам, зааврын дагуу 2022 оны 05 дугаар сарын 02-20-ны хооронд зохион байгуулан эд хөрөнгийн улсын үзлэг тооллого зохион байгуулсан тухай илтгэх хуудас холбогдох материалыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2022 оны 01/268 дугаарын албан бичгээр хүргүүлсэн.

Мөн байгууллагын 2022 оны хагас жилийн үндсэн хөрөнгө, бараа материал, эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг Газрын даргын 2022 оны А/32 дугаар тушаалаар байгуулан эд хөрөнгийн ашиглалт хамгаалалт, эд хөрөнгийн дотоод хөдөлгөөнд хяналт тавьж ажиллав. 2022 оны эхний хагас жилийн байдлаар эвдрэл гэмтэл гарсан, үрэгдсэн эд хөрөнгө байхгүй байна.

5.3.2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИД САНАЛ ӨГСӨН БАЙДАЛ

Газрын чиг үүрэгтэй холбогдох чиглэлээр хуулийн төсөлд өгсөн саналууд.

2.2. Хууль, журмын төсөл, Бодлогын баримт бичигт санал өгөх ажлын хүрээнд

2022 оны хагас жилийн байдлаар газрын хэмжээнд хууль, тогтоомж, норм дүрэм, төсөл, хөтөлбөр арга хэмжээнүүдэд чиг үүргийн хүрээнд нийт 19 чиглэлийн 42 саналыг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Үүнд:

Хүснэгт-7. Санал өгсөн тухай хүснэгт

№	Санал өгсөн баримт бичиг, төслийн төрөл	№	Санал өгсөн баримт бичиг, төслийн нэр	Саналын тоо	Хүргүүлсэн байгууллага
1	Стандарт	1	“Автомат удирдлагатай чингэлэг тээврийн хэрэгсэл JT/T 1377-2021” стандартын төсөлд	3	Стандарт, хэмжил зүйн газарт
		2	Цахилгаан тээврийн хэрэгслийн станцын төрөл, тоноглолыг суурилуулах болон байгуулахад тавих, Ерөнхий шаардлага MNS 6758:2019-д тусгасан таних тэмдгийг Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм болон Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014 стандартад нийцүүлэн тусгаж хэрэглэх талаарх санал	1	Зам тээврийн хөгжлийн яаманд
2	Хууль	3	“Орон сууцны ашиглалтын тухай” хуулийн төсөл	1	Нийслэлийн Засаг даргын тамгын газарт
		4	“Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн төсөл	1	
		5	“Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр олгох тухай” хуулийн төсөл	1	
		6	“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль	1	
3	Журам	7	“Нийслэл хотын хөгжилд хувь нэмэр оруулсан иргэн, хуулийн	9	Улаанбаатар хотын

			этгээдийг дэмжих, урамшуулах журам"-ын төсөл		Захирагчийн ажлын алба
4	Төлөвлөгөө, төсөл хөтөлбөр	8	Монгол Улсын Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөл	1	Нийслэлийн Засаг даргын тамгын газарт
		9	"Хотын иргэний жилийн төлөвлөгөө"-ний төсөл	1	
		10	Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний төсөл	1	
		11	"Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр" МУ-ын дунд хугацааны бодлогын баримт бичиг	1	
		12	"Хот, хөдөөгийн сэргэлтийн ерөнхий цогц төлөвлөгөө"-нд	2	
		13	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөлд	4	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөлд
		14	Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2021 оны төлөвлөгөөнд тусгагдан боловсруулж буй барилгын материалын техникийн нөхцөл, химийн шинжилгээний аргын тухай 8 стандартын баримт бичгийн төсөл	1	Барилгын хөгжлийн төвд
		15	"Сонголонт" төслийн ажлын даалгаврын төсөлд	5	Хот байгуулалт, хөгжлийн газарт
		16	Улаанбаатар хотын төвийн болон алслагдсан дүүрэг, харья дагуул хотуудын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний төсөлд	1	
		17	"Түгжрэлийг бууруулахад чиглэсэн шулуун коридор бүхий дугуйн болон явган замын техникийн зураг төсөл"-д	1	
5		18	Европын сэргэн босголт, хөгжлийн банктай хамтран Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төсөл-д	1	Нийслэлийн Засаг даргын тамгын газарт
		19	"Тэрбум-Мод" үндэсний хөтөлбөрт	1	
		Нийт 5 төрлийн 19 чиглэл			42 Санал


5.3.4. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖИЛ

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдсан “Хаврын баяр” биеийн тамир, спорт өдөрлөгт оролцож байгууллагын спорт хамтлагын үйл ажиллагааг сурталчлан албан хаагчдын дунд 3 төрөлт спорт арга хэмжээг зохион байгуулав.



Зураг-24. Албан хаагчид арга хэмжээнд оролцож буй байдал

- Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, иргэн, гэр бул, байгууллага, хамт олныг нийгмийн олон талт хамтын ажиллагаанд тулгуурлан эрүүл амьдрах хэв маягт төлөвшүүлэх, дасгал хөдөлгөөнийг өдөр бүр хийж илүүдэл жингүй, идэвхтэй иргэнийг бий болгох зорилго бүхий “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” аяны хүрээнд өглөөний дасгалыг зохион байгуулав.



Зураг-25. Албан хаагчид арга хэмжээнд оролцож буй байдал

- 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ойн тухай хууль”-ийн 31.1-т заасны дагуу бүх нийтээр мод тарих арга хэмжээг 13 дахь жилдээ “НОГООН ХОТ-ИРГЭНИЙ ОРОЛЦОО” уриатайгаар зохион байгуулсан мод тарих

үндэсний хөтөлбөрт нэгдэж Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо Бумбатын аманд газрын албан хаагчид мод тарив.



Зураг-26. Албан хаагчид арга хэмжээнд оролцож буй байдал

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатар Марафонд нэгдэцгээ” арга хэмжээнд оролцов.



Зураг-27. Арга хэмжээнд оролцож буй байдал

ДҮГНЭЛТ

Хотын стандарт, хяналтын газар нь 2022 онд шинэчлэн батлагдсан бүтэц, орон тоо, дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж эхлүүлсэн нь газрын үйл ажиллагааг шинэ дүрэм, чиг үүрэгт нийцүүлэн үйл ажиллагааг жигдруулэхэд тодорхой хугацаа шаардсан. Байгууллагын дотоод зохион байгуулалтын нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааг эрчимжүүлж хариуцсан салбар, чиглэлээрээ стандарт, нормоо судлах, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээг санаачлан зохион байгуулах шаардлагатай байна.


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай

хуулиуд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгджэй эхэлсний дагуу хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах гэсэн үндсэн томоохон ажлыг гүйцэтгэсэн. Цаашлаад хотын стандартын тогтолцоог сайжруулах хүрээнд хотын стандартыг боловсруулах, батлуулах үйл ажиллагааны журмыг боловсруулж батлуулах, дараагийн ээлжийн хотын стандартуудыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах томоохон ажлыг зохион байгуулах юм.

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



С.ТӨМӨРДУЛАМ

Э.ДАВААХАТАН

С.БОЛДОО